



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/17

Чингис хот

Төр-Улаан загалмайн хамтын ажиллагааны  
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэзсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Монголын Улаан Загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл, Монгол Улсын шадар сайдан 2017 оны 87 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн захиргааны байгууллага болон Улаан загалмайн хорооны хамтын ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий "Төр-Улаан загалмайн хамтын ажиллагааны салбар зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсугай.

|                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|----------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Дарга                | Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Орлогч дарга         | Аймгийн Улаан Загалмайн Хорооны дарга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| Нарийн бичгийн дарга | Нийгмийн бодлогын хэлтсийн хүн ам зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| Гишүүд               | Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч<br>Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга<br>Нийгмийн бодлогын хэлтсийн дарга<br>Онцгой байдлын газрын дарга<br>Эрүүл мэндийн газрын дарга<br>Боловсролын газрын дарга<br>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга<br>Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга<br>Аймгийн Улаан загалмайн хорооны Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, гамшгийн менежмент хариуцсан мэргэжилтэн |

2. Салбар зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3. Төр-Улаан загалмайн хамтын ажиллагааны салбар зөвлөлийг журмын дагуу ажиллуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн дарга аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/132 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010073

**ТӨР-УЛААН ЗАГАЛМАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Төр, улаан загалмай хамтын ажиллагааны салбар зөвлөл /цаашид салбар зөвлөл гэх/-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Хүмүүнлэгийн чиглэлээр Төр, улаан загалмай хамтын ажиллагааг орон нутгийн хэмжээнд удирдан чиглүүлэх, зохицуулах үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөл байна.

1.3. Төр, улаан загалмай хамтын ажиллагааны салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол улсын гамшгаас хамгаалах хууль, Монголын улаан загалмай нийгэмлэгийн Эрх зүйн байдлын тухай болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичгийг удирдлага болгоно.

**Хоёр. Төр, улаан загалмай хамтын ажиллагааны  
салбар зөвлөлийн удирдлага зохион байгуулалт**

1.1. Төр, улаан загалмай хамтын ажиллагааны салбар зөвлөл нь аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд ажиллана.

1.2. Хамтын ажиллагааны салбар зөвлөл нь орлогч дарга, нарийн бичгийн даргатай байна.

1.3. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд холбогдох төрийн байгууллага, аймгийн Улаан Загалмайн Хорооны төлөөлөл орсон байна. Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцэх асуудалтай уялдуулан холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөл хуралдаанд оролцож болно.

1.4. Аймаг, дүүргийн түвшинд Төр, улаан загалмай хамтын ажиллагааны салбар зөвлөлийг тухайн аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга ахална.

1.5. Аймаг, дүүргийн хамтын ажиллагааны салбар зөвлөлийн ажлын албаны үүргийг аймаг, дүүргийн Улаан Загалмайн Хороо гүйцэтгэнэ.

1.6. Аймаг, дүүргийн хамтын ажиллагааны салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн аймаг, дүүргийн Засаг дарга батална.

1.7. Хамтын ажиллагааны салбар зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

**Гурав. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн  
чиг үүрэг, үйл ажиллагаа**

3.1. Хамтын ажиллагааны салбар зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Монголын улаан загалмай нийгэмлэгийн Эрх зүйн байдлын тухай хуулийн 6.3, 10.3 дахь заалтыг үндэслэн хамтран ажиллах;

3.1.2. Төрөөс Хүмүүнлэгийн талаар баримтлах бодлого, үйл ажиллагаа, гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг бусад салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилттэй уялдуулан зохицуулах, салбар дундын оролцоог хангах чиглэлээр шийдвэр гаргах;



3.1.3. Хүмүүнлэгийн үйл ажиллагааны санхүүжилтийг орон нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.1.4. Хүн амын нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, сайн дурын авлагагүй цусны донорын хөдөлгөөнийг өргөжүүлэх, орон нутгийн хэмжээнд аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах, зонхилон тохиолдох нийгмийг хамарсан гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөл эндэгдлийг бууруулахад холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих;

3.1.5. Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахад туслах, эрсдэлийг бууруулах, нэрвэгсдэд яаралтай тусламж, нийгмийн сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдлагаар хангах;

3.1.6. Гамшиг, осол, нийтэд учирсан гамшигт байдлын үед хэнийг ч үл ялгаварлан анхны тусламж, нийгмийн сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдлагаар хангах;

3.1.7. Олон нийтийн оролцоонд түшиглэн нийгмийн эмзэг бүлэгт халамжийн үйлчилгээ үзүүлэх, хүн амын амьжиргааг дээшлүүлэх, гамшгийн дараах нөхөн сэргээх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3.1.8. Олон улсын хүмүүнлэгийн хуулийн хэрэгжилтийн талаар санал солилцож, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх, сурталчлах, хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд хангах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлэх;

3.1.9. Хүмүүнлэгийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, МУЗН-ийн гишүүнчлэл, хүмүүнлэгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх;

3.1.10. Төр, улаан загалмай хамтын ажил тагааны салбар зөвлөл өөрийн бүрэн эрхэд хамаарах бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

3.2. Төр, улаан загалмай хамтын ажиллагааны салбар зөвлөл нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

3.2.2. Хамтын ажиллагааны салбар зөвлөл нь жилд 2 удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд хамтын ажиллагааны салбар зөвлөлийн дарга ээлжит бус хуралдаан зарлан хуралдуулж болно.

3.2.3. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

3.2.4. Хамтын ажиллагааны салбар зөвлөл хэлэлцсэн асуудлаараа тогтоол гаргах бөгөөд тогтоолд зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

3.2.5. Хамтын ажиллагааны салбар зөвлөл нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой зарим асуудлаар зөвлөмж гаргаж болно.

3.3. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн дарга үйл ажиллагаандаа дараах чиглэлийг баримтална:

3.3.1. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэлэлцэх асуудлын жагсаалт болон хуралдаанаас гарах шийдвэрийг баталж, шаардлагатай гэж үзвэл зарим асуудлыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

3.3.2. Хуралдааныг хамтын ажиллагааны салбар зөвлөлийн дарга зарлаж, удирдах бөгөөд түүний эзгүйд орлогч дарга зарлаж, удирдана.

3.3.3. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн хуралдаанаас гаргасан тогтоол, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэн удирдаж, бусад салбарын оролцоог хангуулна.

3.4. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараах үүргийг гүйцэтгэнэ:

3.4.1. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэлэлцэх асуудлын жагсаалт, хурлын тов, хуралдаанаас гарсан шийдвэрийг хамтын ажиллагааны салбар зөвлөлийн даргаар батлуулна.

3.4.2. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохицуулж, хуралдааны бэлтгэл ажлыг хангана.

3.4.3. Хуралдаанаас гарсан тогтоол, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

3.4.4. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн тайланг нэгтгэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

3.5. Төр, улаан загалмай хамтын ажиллагааны салбар зөвлөлийн ажлын албаны үүргийг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс гүйцэтгэх бөгөөд дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

3.5.1. Төр, улаан загалмай хамтын ажиллагааны салбар зөвлөлийн хуралдаан зохион байгуулах, хэлэлцэх асуудлын бэлтгэл болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон бэлтгэл ажлыг хангана.

3.5.2. Хамтын ажиллагааны зөвлөлөөс гарсан тогтоол, зөвлөмжийн биелэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагаас гаргуулан авч, мэдээлэл солилцоно.

3.5.3. Хамтын ажиллагааны салбар зөвлөлийн архив, бичиг хэргийг хөтлөн явуулна.